



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Г Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг Г
бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХХК-ийн нэг бүр нь 5.67 төгрөг /таван төгрөг жаран долоон мөнгө/-ийн нэрлэсэн үнэ бүхий нийт 408,850,428 /дөрвөн зуун найман сая найман зуун тавин мянга дөрвөн зуун хорин найм/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Монос хүнс” ХХК-ийн нэг бүр нь 5.67 төгрөг /таван төгрөг жаран долоон мөнгө/-ийн нэрлэсэн үнэ бүхий нийт 286,195,300 /хоёр зуун наян зургаан сая нэг зуун ерэн таван мянга гурван зуу/ ширхэг хувьцааны өмчлөх эрхийг энэхүү тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын 1-д заасан хувьцаанаас 122,655,128 /нэг зуун хорин хоёр сая зургаан зуун тавин таван мянга нэг зуун хорин найм/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийн үнийг 70 /дал/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “Монос хүнс” ХХК /П.Тодрол/-д зөвшөөрсүгэй.

4. Тогтоолын 3-д заасан нийтэд санал болгон худалдах хувьцааны 50 хувь буюу 61,327,564 /жаран нэгэн сая гурван зуун хорин долоон мянга таван зуун жаран дөрөв/ ширхэг хувьцааг “Голомт капитал ҮЦК” ХХК-ийн тодорхойлсон стратегийн хөрөнгө оруулагчид худалдахыг зөвшөөрсүгэй.

5. Тогтоолын 3-д заасан нийтэд санал болгон худалдаалах хувьцааг 100 /нэг зуу/ хувь зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцохыг “Монос хүнс” ХХК /П.Тодрол/-д мэдэгдсүгэй.

6. Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

7. Тогтоолын 2, 4-т заасан хувьцаа эзэмшигчийн эзэмшилд буй хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлахыг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

E:\ajil 2019\Blank\Togtool.doc

000064


8. Тогтоолын 5-д заасан нийтэд санал болгон худалдах хувьцааны 100 /нэг зуу/ хувийг анхдагч зах зээлд арилжаалж, шаардлагатай хөрөнгийг татан төвлөрүүлж чадаагүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Голомт капитал ҮЦК” ХХК /О.Мөнхжаргал/-д анхааруулсугай.

9. “Монос хүнс” ХХК нь нээлттэй хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Монос хүнс” ХХК /П.Тодрол/-д үүрэг болгосугай.

10. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Голомт капитал ҮЦК” ХХК /О.Мөнхжаргал/, “Өмгөөллийн И Эл Си” ХХН /Б.Баяр/, “Итгэлт-Эстимэйт” ХХК /Ө.Эрдэнэбаяр/, “Грант торнтон аудит” ХХК /Б.Осоргарав/-д тус тус анхааруулсугай.

11. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /М.Өлзийбат/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 03 дугаар сарын 13-ны
өдрийн 28 дугаар тогтоолын хавсралт



№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо ширхэг	Хувьцааны эзэмшлийн хувь
1	Л.Хүрэлбаатар	286,195,300	70.00%
	Нийт дүн	286,195,300	70.00%